



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 1/94

Улаанбаатар хот

Г Т

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалт, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигчийн мэдүүлэг”-ийн маягтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т, журам хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг хууль, эрх зүйн хүрээнд холбогдох эх үүсвэрээс жил бүр шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т тус тус даалгасугай.

3. Журам хэрэгжүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэнд, анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, эрүүл мэндийн байгууллага, олон улсын байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагын оролцоог ханган ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 223 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080347



Эрүүл мэндийн сайдын 2016 оны  
10.. сарын 1... өдрийн 11 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

### “Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэтгэлэг” олгох журам

#### НЭГ. Нийтлэг үндэслэл.

1.1. Эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлээр бакалавр, диплом, мэргэжлийн болон техникийн боловсрол олгох дотоодын сургалтын байгууллага (цаашид “сургууль” гэх)-д суралцаж буй оюутан (цаашид “оюутан” гэх)-д Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэтгэлэг (цаашид “тэтгэлэг” гэх) олгоход энэхүү журмыг баримтална.

1.2. Журмын зорилго нь оюутны сурч боловсрох идэвхийг дээшлүүлэх, мэдлэг чадварыг хөгжүүлэх, урамшуулан дэмжих, эрүүл мэндийн салбарт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтны гэр бүлд дэмжлэг үзүүлж, нийгмийн баталгааг хангах, орон нутгийг шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнээр хангахад оршино.

1.3. Оюутанд олгох тэтгэлэг нь төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлийн сургуульд адил тэгш хамаарна.

#### ХОЁР. Тэтгэлгийн төрөл.

2.1. Тэтгэлэг нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- 2.1.1. Сургалтын төлбөр (нийт 10 сарын хугацаанд олгох сар бүрийн 100.000 төгрөгийн тэтгэлэг);
- 2.1.2. Гадаад улсад эрүүл мэндийн чиглэлээр танилцах аялалд оролцуулах зардал;
- 2.1.3. Судалгааны ажлын зардал;
- 2.1.4. Оюутан солилцооны хөтөлбөрт хамруулах зардал;
- 2.1.5. Гадаад хэлний сургалтад суралцуулах зардал.

#### ГУРАВ. Тэтгэлэг олгох шалгуур.

3.1. Тэтгэлэгт дараах нийтлэг шалгуурыг хангасан оюутан нэр дэвшинэ. Үүнд:

3.1.1. Эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад элсэн суралцаж байгаа өдрийн ангийн оюутан байх;

3.1.2. Эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 1 ба түүнээс дээш улирал дараалан 3.4-өөс доошгүй голч дүнтэй суралцсан байх;

3.1.3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд идэвхтэй оролцон, эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, байр эзэлсэн байх;

3.1.4. Олон нийтийн ажилд идэвх санаачилгатай оролцдог, хамт олныхоо дунд нэр хүндтэй байх;

3.1.5. Бусад нэрэмжит тэтгэлэг, түүнтэй адилтгах шагналыг нэр дэвших үедээ аваагүй байх.

3.2. Тэтгэлэг олгоход дараахь тусгай шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:

3.2.1. Эцэг, эхийн аль нэг нь эрүүл мэндийн салбарт 15 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан;

3.2.2. Хагас болон бүтэн өнчин оюутан;

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан;

3.2.4. Гэр бүлийн орлого нь амьжиргааны доогуур түвшинд байдаг оюутан;

3.2.5. Орон нутгаас элсэн суралцаж байгаа нөхцөлд төгсөөд тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллахаар гэрээ байгуулсан байх.

## **ДӨРӨВ. Тэтгэлэгт нэр дэвшиүүлэх, шалгаруулах**

4.1. Энэхүү журмын 3.1, 3.2-т заасан шалгуурыг хангасан оюутан өөрөө буюу оюутны анхан шатны байгууллага, сургуулийн захиргаа, багш нь тухайн оюутныг тэтгэлэгт нэр дэвшиүүлж болно.

4.2. Тэтгэлэгт нэр дэвшигч нь доорхи баримт бичгийг жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор суралцаж байгаа сургуулийн захиргаанд өгнө. Үүнд:

4.2.1. "Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэтгэлэгт нэр дэвшигчийн мэдүүлэг" (маягтын дагуу);

4.2.2. Сургуулийн захиргаа, оюутны анхан шатны байгууллагын тодорхойлолт (өмнө авч байсан бусад тэтгэлэг, эрүүл мэндийн болон хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээлэл багтаасан байх);

4.2.3. Оршин суугаа хорооны тодорхойлолт (өнчин, амьжиргааны доод түвшиний орлоготой гэр бүлийн гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй оюутны хувьд);

4.2.4. Сургуулийн сургалтын албаны баталгаажуулсан дүнгийн жагсаалт, голч дүнгийн тодорхойлолт;

4.2.5. Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаархи санал бүхий эссе (1000 үгэнд багтаасан байх);

4.2.6. Эцэг, эхийн албан байгууллагын тодорхойлолт (эцэг, эхийн аль нэг нь эрүүл мэндийн салбарын ажилтан тохиолдолд).

4.3. Сургуулийн захиргаанаас байгуулсан сургалтын алба, оюутны анхан шатны байгууллага, багшийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг нь нэр дэвшигчдийн баримт бичгийг хянаж, оюутан тус бүрт дүгнэлт гаргана. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, дүгнэлт, шалгуур хангасан оюутны нэр, энэхүү журмын 4.2-т заасан баримт бичгийг

сургуулийн захирлаар баталгаажуулан, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.

4.4. Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь сургуулиудаас ирүүлсэн оюутны баримт бичгийг хянаж, тэтгэлэг олгох шалгуур хангасан оюутны асуудлыг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ба хуралд тэтгэлгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх байгууллагын төлөөллийг оролцуулна. Эрүүл мэндийн сайд Удирдлагын зөвлөлөөс гарсан шийдвэртэй танилцаж, эцсийн шийдвэр гаргана.

4.5. Журмын 3.2-т заасан тусгай шалгуур нь тэтгэлэг олгох оюутныг сонгоход давуу тал болно.

4.6. Тэтгэлэгт хамрагдах оюутнуудын 80 хүртэл хувь нь журмын 3.2.1-д заасан тусгай шалгуурыг хангасан, үлдсэн 20 хувь нь журмын 3.2.2-3.2.5-д заасан тусгай шалгуурт нийцсэн байна.

4.7. Тэтгэлэгт шалгарсан оюутанд Эрүүл мэндийн сайд болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг бүхий өргөмжлөлийг ёслол төгөлдөр гардуулна.

#### **ТАВ.Тэтгэлгийн санхүүжилт.**

Тэтгэлгийн санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 1.1. Улсын төсвийн хөрөнгө;
- 1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 1.3. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэнд, анагаах ухааны боловсрол олгох сургууль;
- 1.4. Олон улсын байгууллагын хандив, тусlamж;
- 1.5. Аж, ахуйн нэгж байгууллага, иргэний хандив, тусlamж;
- 1.6. Бусад эх үүсвэр.

#### **ЗУРГАА. Бусад зүйл.**

6.1. Тэтгэлэгт хамрагдсан оюутны талаархи мэдээлэл, танилцуулгыг Эрүүл мэндийн яамны вэб хуудаст тухай бүр байршуулж, олон нийтэд мэдээлнэ.

6.2. Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэтгэлэгт оюутан нь шалгуур хангасан бол дахин нэр дэвших эрхтэй.

6.3. Тэтгэлэгтэй оюутан нь баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, сургуулиас хасагдсан тохиолдолд тэтгэлгийг нөхөн төлүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2016 оны  
10. сарын 21. өдрийн дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

“ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТЭТГЭЛЭГТ НЭР  
ДЭВШИГЧИЙН МЭДҮҮЛЭГ”-ИЙН МАЯГТ

1. Ургийн овог \_\_\_\_\_
2. Эцэг (эхийн) нэр \_\_\_\_\_
3. Эцэг (эхийн) ажлын хаяг, албан тушаал, оршин суугаа хаяг  
\_\_\_\_\_
4. Өөрийн нэр \_\_\_\_\_
5. Хүйс (сонгож чагтлах)  эмэгтэй  эрэгтэй
6. Төрсөн он 

|  |  |  |
|--|--|--|
|  |  |  |
|--|--|--|

 сар 

|  |  |
|--|--|
|  |  |
|--|--|

 өдөр 

|  |  |
|--|--|
|  |  |
|--|--|
7. Регистрийн дугаар 

|  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|
8. Төрсөн газар \_\_\_\_\_
9. Үндсэн захиргаа \_\_\_\_\_
10. Оршин суугаа хаяг \_\_\_\_\_
11. И-мэйл хаяг \_\_\_\_\_
12. Утасны дугаар  
Гар утас  
Гэрийн утас 

|  |  |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |  |  |  |  |
|  |  |  |  |  |  |  |  |
|  |  |  |  |  |  |  |  |
13. Суралцаж байгаа сургууль, анги, мэргэжил, улирал, голч дүн  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
14. Тэтгэлэгт нэр дэвших үндэслэл  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
15. Бусад тэтгэлэг, түүнтэй адилтгах шагнал авч байсан болон байгаа эсэх  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

3x4  
хэмжээтэй  
зураг